Т А Н И Л Ц У У Л Г А

Тогтоолын хавсралтад
өөрчлөлт оруулах тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг 1999 оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсөн. Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Өндөр насны тэтгэвэр бодох арга дараах төрөлтэй байна:” гэж, 6.1.2 дахь заалтад “нэрийн дансны.” гэж тус тус зааснаар нэрийн данс өндөр насны тэтгэвэр бодох нэг арга байхаар зохицуулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн даатгуулагч цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаас өөрийн сонголтоор, харин 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэврийг тогтоолгохоор хуульчилсан.

2026 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 8 даатгуулагч өндөр насны тэтгэврийг нэрийн дасны аргаар тогтоолгосон.

1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн даатгуулагчид хийсвэр аргаар бүртгэсэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны нийт үлдэгдэл бага байгаагаас тус аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ цалинд үндэслэсэн аргаар тэтгэвэр тогтоолгож буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнээс 1,5-3 дахин бага тогтоогдож ирээдүйд ахмад настны орлогын хэмжээ буурч, нийгмийн хамгаалал алдагдах нөхцөл байдал үүссэн тул Улсын Их Хурлын 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл" гэснийг "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн бүртгэл" гэж, өндөр насны тэтгэвэр бодох “нэрийн дансны” аргыг “хуримтлалд үндэслэсэн” гэж тус тус өөрчлөн найруулсан.

Ингэснээр даатгуулагч цаашид өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн аргаар шимтгэл төлсөн хугацаа, цалингийн хэмжээнээс хамаарсан шударга тэтгэвэр авах, мөн тэтгэврийн мөнгөн хуримтлалд хуримтлуулсан хуримтлалын хэмжээнээс хамаарсан хуримтлалын тэтгэвэр авах боломж бүрдсэн.

Үүний дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан өндөр насны тэтгэвэр бодох нэрийн дансны аргыг хуримтлалд үндэслэсэн гэж өөрчлөн найруулж, 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн, мөн хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаас өөрөө сонгох зохицуулалтыг хүчингүй

болгон 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөхөөр заасан.

Иймд дээрх хуулийн өөрчилсөн, хүчингүй болсон хэсэг, заалтай холбогдуулан Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын 2.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах тухай Засгийн газрын “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг боловсруулласа.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ